



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

**Зорчигч тээврийн үйлчилгээнд хамаарах
хотын стандартыг батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10¹.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Зорчигч тээврийн үйлчилгээ бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1.1. UCS1601B:2022 “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг нэгдүгээр хавсралтаар;

1.2. UCS1602B:2022 “Такси зогсоолд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг хоёрдугаар хавсралтаар;

1.3. UCS1603B:2022 “Нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг гуравдугаар хавсралтаар;


1.4. UCS1604B:2022 “Хүүхдийн автобусанд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг дөрөвдүгээр хавсралтаар;

1.5. UCS1605B:2022 “Такси үйлчилгээнд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг тавдугаар хавсралтаар;

2. Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3. Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100070